



МОНГОЛ УЛС  
МОНГОЛБАНК

Бага тойруу 3, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: (976-11) 31 03 92, Факс: (976-11) 31 14 71,  
Цахим хуудас: www.mongolbank.mn

2026.06.04 № А-1/482  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Монголбанкны Тэргүүн дэд Ерөнхийлөгчөөр  
томилуулах санал өргөн мэдүүлэх тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсгийг үндэслэн Монголбанкны Тэргүүн дэд Ерөнхийлөгчөөр Энхболдын Анарыг томилуулах саналыг өргөн мэдүүлж байна.

Э.Анар нь 1984 онд Улаанбаатар хотод төрсөн, 1992-2001 онд Нийслэлийн 10-н жилийн 1 дүгээр дунд сургууль, 2001-2004 онд Япон Улсын Хакүо ахлах сургууль, 2004-2008 онд Япон Улсын Хакүо Их сургуулийг Бизнесийн удирдлагын бакалавр зэрэгтэй төгссөн бөгөөд 2007-2008 онд АНУ-ын Индианагийн Их сургууль, 2014-2015 онд АНУ-ын Колумбын Их сургуульд тус тус суралцаж Эдийн засгийн бодлогын удирдлагын магистрын зэрэг хамгаалсан. Англи, Япон хэлтэй.

Э.Анар нь 2011-2013 онд Монголбанкны Валют, эдийн засгийн газрын Гадаад валютын нөөцийн хэлтсийн нөөцийн мэргэжилтэн, 2013-2016 онд Монголбанкны Хяналт шалгалтын газрын Зайнаас хяналт тавих хэлтсийн хянан шалгагч, 2016-2017 онд Монгол банкны Төлбөр тооцоо, бүртгэлийн газрын захирал, 2017-2026 онд Монголбанкны Төлбөр тооцооны газрын захирлаар ажилласан туршлагатай ба 2026 оноос Монголбанкны Төлбөрийн систем, технологийн газрын захирлаар ажиллаж байна.

Монголбанкны Тэргүүн дэд Ерөнхийлөгчөөр Э.Анарыг томилуулах саналыг өргөн мэдүүлэхдээ түүний эдийн засаг, банк, санхүү, удирдлагын мэдлэг, мэргэшлийн ур чадвар, мэргэжлийн ёс зүй, ажлын дадлага туршлагыг харгалзан үзсэн болно.

Хавсралт ...9... хуудастай.

Хүндэтгэсэн

ЕРӨНХИЙЛӨГЧ



С.НАРАНЦОГТ

1526021936

**МОНГОЛБАНКНЫ ТЭРГҮҮН ДЭД ЕРӨНХИЙЛӨГЧ,  
ДЭД ЕРӨНХИЙЛӨГЧИД НЭР ДЭВШИХ ТУХАЙ ХҮСЭЛТ**

**Товч удирдамж:** Нэр дэвших тухай хүсэлт гаргахдаа энэхүү загварт асуусан асуулт, шаардсан мэдээлэл бүрийн доор /ард/ хариултаа үнэн зөв бичнэ. Компьютерын програм ашиглаж бичсэн хүсэлтийг цаасаар хэвлэж гарын үсэг зурах бөгөөд уг эх хувь, түүний хавсралт мөн Word-ын файлыг цахим шуудангаар тус тус Байнгын хороонд явуулна.

**Хуульд заасан шаардлага:** Төв банк/Монголбанк/-ны тухай хуулийн 26.3-т заасан шаардлагыг хангасан байна. Үүнд:

3.Монголбанкны Ерөнхийлөгч, Тэргүүн дэд ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгчийг томилохдоо түүний эдийн засаг, банк, санхүү, удирдлагын мэдлэг, мэргэшлийн ур чадвар, мэргэжлийн ёс зүй, ажлын туршлагыг харгалзана.

**НЭГ. НЭР ДЭВШИГЧИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА, НИЙТЛЭГ ШААРДЛАГА**

1.1	<p><b>Эцэг/эхийн нэр:</b> Энхболд  <b>Ургийн овог:</b> Боржигин  <b>Нэр:</b> Анар  <b>Хүйс:</b> Эрэгтэй  <b>Төрсөн он:</b> 1984 он  <b>Төрсөн газар:</b> Улаанбаатар хот. 1 дүгээр төрөх эмнэлэг  <b>Иргэний харьяалал:</b> Улаанбаатар хот  <b>Одоо оршин суугаа аймаг/нийслэл, сум/дүүрэг:</b> Улаанбаатар хот, Хан Уул дүүрэг 11-р хороо Сөүл каунти 308-502 тоот /Мэдээлэл гаргагчийн зөвшөөрлөөр/</p>
1.2	<p><b>Нэр дэвших тухай хүсэлт гаргаж буй албан тушаал</b>          Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгч</p>
1.3	<p><b>Иргэний харьяалал</b>          Монгол Улсын иргэн мөн эсэх /тийм, эсхүл үгүй гэж бичих/.          Монгол Улсаас өөр улсын иргэний харьяалалтай байсан эсэх /тийм, эсхүл үгүй гэж бичих/.          Монгол Улсын иргэн, өөр улсын харьяалал байхгүй.</p>
1.4	<p><b>Боловсрол</b>          Дээд боловсрол эзэмшсэн сургууль тус бүрийг сүүлд төгссөн сургуулиас нь эхлэн он дарааллаар жагсааж, холбогдох нотлох баримтыг хавсаргана.  <u>Сургууль тус бүрд суралцсан хугацаа, авсан зэрэг, огноог бичнэ.</u>          Нийслэлийн 10-н жилийн 1-р дунд сургууль 1992-2001 он          Хагүро ахлах сургууль Япон улс, 2001-2004 он          Хакүо их сургууль, Бизнесийн удирдлагын бакалвр, Япон улс, 2004-2008 он          Колумбын их сургууль, Эдийн засгийн бодлогын удирдлагын магистр, АНУ, 2014-2015 он</p>
1.5	<p><b>Боловсролын болон шинжлэх ухааны докторын зэрэг</b></p>
1.6	<p><b>Эрүүл мэнд</b>          Сэтгэцийн өвчин, эмгэгтэй эсэхийг тодорхойлсон нотлох баримтыг жагсааж, хавсаргана.          Үгүй</p>

1.7	<p><b>Эрхэлсэн ажил</b> Их, дээд сургууль төгссөнөөс хойш эрхэлсэн ажлыг тодорхойлон бичнэ. Эдийн засаг , банк, санхүүгийн чиглэлээр 10 (12)-аас дээш жил ажилласан туршлагатай, удирдлагын мэдлэг, мэргэшлийн ур чадвартай болохыг нотлох баримтыг хавсаргана. Ажилласан байгууллагыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар жагсаах бөгөөд ажил олгогч /эсхүл, удирдах албан тушаалтан/-ийн нэр, хаяг, утасны дугаар, цахим шуудангийн хаяг, цахим хуудас болон ажлын байрны нэрийг бичнэ.</p> <p>МОНГОЛБАНК Төлбөрийн систем, технологийн газар, Газрын захирал, 2026- одоог Төлбөр тооцооны газар, Газрын захирал, 2017-2026 он Төлбөр тооцоо, бүртгэлийн газар, Газрын захирал, 2016-2017 он Хяналт шалгалтын газар, Зайнаас хяналт тавих хэлтэст, хянан шалгагч, 2013-2014 он Валют, эдийн засгийн газар, Гадаад валютын нөөцийн хэлтэст, нөөцийн мэргэжилтэн,2011-2013 он</p>
1.8	<p><b>Улс төрийн болон намын удирдах, гүйцэтгэх албан тушаал</b></p> <p>Сүүлийн таван жил улс төрийн албан тушаал болон улс төрийн намын удирдах, гүйцэтгэх албан тушаал эрхэлж байсан эсэхийг бичих. /тийм, эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, ямар албан тушаалыг ямар хугацаанд эрхэлж байгаа, эсхүл эрхэлж байсан талаараа хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.</p> <p>Үгүй</p>
1.9	<p><b>Мэргэжлийн ёс зүйн талаар</b></p> <p>-Мэргэжлийн ёс зүйн зөрчил гаргаж байсан эсэх /тийм эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.</p> <p>Үгүй</p>
1.1 0	<p><b>Мэргэжлийн холбоо, байгууллагын гишүүнчлэлийн талаар</b></p> <p>-Мэргэжлийн холбоо, байгууллагад эрхэлж байсан албан тушаал, гүйцэтгэсэн чиг үүрэг, огноог хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичнэ.</p> <p>Олон улсын банк хоорондын харилцаа холбооны нийгэмлэг (SWIFT), Монгол Улсыг төлөөлөх удирдах зөвлөлийн гишүүн /2022 оноос/ Олон улсын сагсан бөмбөгийн холбоо, Зүүн Азийн сагсан бөмбөгийн холбооны удирдах зөвлөлийн гишүүн /2023 оноос/ Олон улсын сагсан бөмбөгийн холбоо, Азийн сагсан бөмбөгийн холбооны санхүүгийн зөвлөлийн гишүүн /2023 оноос/ Тэрбум мод сан, удирдах зөвлөлийн гишүүн /2023 оноос/ Монголын Үндэсний Олимпын хорооны гишүүн /2022 оноос/ Монголын сагсан бөмбөгийн холбоо, Дэд Ерөнхийлөгч /2022 оноос/ бөгөөд Удирдах зөвлөлийн гишүүн /2014 оноос/ Монголын Морин Спорт Уяачдын холбооны удирдах зөвлөлийн гишүүн /2020 оноос/</p>
1.1 1	<p><b>Нэр дэвшигч нь хэрэв байгаа бол доор дурдсан мэдээллийг бичнэ</b></p> <p>-Өөрийн боловсруулсан, хянасан судалгааны ажил, ном, өгүүлэл, тайлан, шийдвэр, зөвлөмж зэрэг аливаа хэлбэрээр хэвлүүлсэн материал байгаа бол гарчиг, хэвлэсэн газар, огноог бичнэ.</p> <p>-Өөрийн харьяалагддаг байгууллагын нэрийн өмнөөс бэлдсэн, эсхүл бэлдэхэд оролцсон аливаа хууль тогтоомж, дүрэм, журам, шийдвэр, тайлан,</p>

зөвлөмж болон бусад материал байгаа бол түүнийг хэвлэсэн байгууллагын нэр, хаяг, огноо, гол агуулгыг бичнэ.

-сүүлийн таван жилийн хугацаанд хэлэлцүүлсэн лекц, илтгэл, нээлтийн үг зэрэг илтгэл, ярианы товч утга, огноо, газар, танилцах арга замыг бичнэ. Тухайн илтгэл, ярианы хуулбарыг хийх боломжгүй бол түүнийг зохион байгуулсан байгууллагын нэр, хаяг, илтгэл, ярианы огноо, товч утгыг бичнэ.

-сүүлийн таван жилийн хугацаанд хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд өгсөн ярилцлага, нийтлэлийг хамгийн сүүлийнхээс нь эхлэн жагсааж бичнэ. Ярилцлага, нийтлэлүүдийн огноог зааж, боломжтой бол ярилцлагын тэмдэглэл, дүрс бичлэг, нийтлэлийг хуулбарлан өгнө.

**Жич:** Дээр дурдсан материал тус бүрээс нэгийг хавсаргах бөгөөд боломжтой бол цахимаар үзэх линкийг тусгана.

- Монгол Улсын Үндэсний Төлбөрийн Системийг Хөгжүүлэх Стратеги, Улаанбаатар, 2016 он,  
<https://www.mongolbank.mn/mn/r/1355>
- Монгол Улсын Үндэсний төлбөрийн системийг 2022-2026 онд хөгжүүлэх стратеги, Улаанбаатар, 2022 он,  
<https://www.mongolbank.mn/mn/r/3948>
- Монгол Улсын Финтек инновацын замын зураглал, Улаанбаатар, 2025 он
  
- **ҮНДЭСНИЙ ТӨЛБӨРИЙН СИСТЕМИЙН ТУХАЙ** хуультай болох ажлыг анхлан санаачилж, эхний төслийг боловсруулсан бөгөөд хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлдэх дэд ажлын хэсэгт орж тус хуулийг УИХ-ын холбогдох байнгын хороод, УИХ-ын нэгдсэн чуулганаар хэлэлцүүлэн батлуулсан.  
<https://leginfo.mn/mn/detail/12668>
- Төлбөрийн систем дэх хяналт, зохицуулалтыг гүйцэтгэх үндсэн чиглэлийг тодорхойлох зорилготой “Төлбөрийн системийн хяналтын бодлого”, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн А-149 дугаар тушаал,  
[https://www.mongolbank.mn/file/d4765f10a3df3f91770a8691c81b5930/files/20210625\\_A149.pdf](https://www.mongolbank.mn/file/d4765f10a3df3f91770a8691c81b5930/files/20210625_A149.pdf)
- Төлбөрийн системийн бүх дүрэм, журам, зохицуулалтыг нэгтгэн “Төлбөрийн системийн журам” болгон төсөл боловсруулсан бөгөөд 2021 онд анхлан батлуулсан. Төлбөрийн системийн журамд орсон 6 удаагийн нэмэлт, өөрчлөлт, журмыг 3 удаа шинэчлэн батлуулах ажлыг хийж гүйцэтгэсэн. Монголбанкны Ерөнхийлөгчийн 2023 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн А-91 дугаар тушаал,  
<https://leginfo.mn/mn/detail?lawId=16759495133261>
- Банк хоорондын 5 сая төгрөгөөс дээш дүнтэй гүйлгээг зохицуулах “Их дүнтэй төлбөрийн системийн дүрэм”, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2025 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн А-229 дугаар тушаал,  
<https://leginfo.mn/mn/detail?lawId=17433830186002>
- Банк хоорондын 5 сая төгрөгөөс доош дүнтэй гүйлгээ, багцын гүйлгээ, дансны нэгдсэн сан, дебит гүйлгээний системийг зохицуулах “Автомат клиринг хаус системийн дүрэм”, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн А-128 дугаар тушаал,  
<https://leginfo.mn/mn/detail?lawId=16230567194261>
- Банк хоорондын картын гүйлгээг зохицуулах “Монголбанкны картын клирингийн системийн дүрэм”, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2022 оны 5 дугаар сарын 02-ны өдрийн А-135 дугаар тушаал,  
<https://leginfo.mn/mn/detail?lawId=16530281902581>

- Төлбөрийн системийн оролцогчид, зохицуулагч байгууллагын хамтын ажиллагааг идэвхжүүлж, дэмжих зөвлөлийн үйл ажиллагааг зохицуулах “**Үндэсний төлбөрийн системийн зөвлөлийн дүрэм**”, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А-261 дугаар тушаал,  
<https://www.mongolbank.mn/file/d4765f10a3df3f91770a8691c81b5930/files/%D0%90-261%20%D0%B7%D3%A9%D0%B2%D0%BB%D3%A9%D0%BB.pdf>
- Шинэ санаа, шинэлэг технологийн хөгжлийг дэмжих “**Монголбанкны инновацын төвийн үйл ажиллагааны дүрэм**”, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2025 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн А-231 дугаар тушаал,  
[https://www.mongolbank.mn/file/d4765f10a3df3f91770a8691c81b5930/files/2025\\_10\\_06%20%D0%90-231\(1\).pdf](https://www.mongolbank.mn/file/d4765f10a3df3f91770a8691c81b5930/files/2025_10_06%20%D0%90-231(1).pdf)
- Олон улсын дансны нэгдсэн дугаарлалтын стандарт (IBAN)-ыг Монгол Улсад хэрэгжүүлэх хүрээнд гаргасан “**Дансны нэгдсэн дугаарлалт нэвтрүүлэх тухай**” Монголбанкны Ерөнхийлөгчийн 2020 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн А-66 дугаар тушаал,  
<https://www.mongolbank.mn/file/d4765f10a3df3f91770a8691c81b5930/files/%D0%90-66.pdf>
- QR код дээр суурилсан шинэлэг төлбөрийн үйлчилгээний стандартыг батлах тухай “**QR кодын мессежний бүтэц, заавар**”, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2024 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн А-149 дугаар тушаал  
<https://www.mongolbank.mn/file/d4765f10a3df3f91770a8691c81b5930/files/2024%20A-149.pdf>
- Нэн чухал төлбөрийн системийн найдвартай байдлыг хангах “**Санхүүгийн зах зээлийн дэд бүтцийг үнэлэх аргачлал**”, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2015 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн А-98 дугаар тушаал,  
<https://www.mongolbank.mn/file/d4765f10a3df3f91770a8691c81b5930/files/>
- Төлбөрийн системийн оролцогчдын тайлагналыг зохицуулах “**Төлбөрийн системийн тайлан гаргах заавар**”, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн А-160 дугаар тушаал  
<https://www.mongolbank.mn/file/d4765f10a3df3f91770a8691c81b5930/files/%D0%90-160.pdf>
- Төлбөрийн системийн оролцогчид олгох “**Зөвшөөрлийн гэрчилгээний загвар**”, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн А-21 дугаар тушаал,  
[https://www.mongolbank.mn/file/d4765f10a3df3f91770a8691c81b5930/files/2024\\_02\\_23%20%D0%90-21.pdf](https://www.mongolbank.mn/file/d4765f10a3df3f91770a8691c81b5930/files/2024_02_23%20%D0%90-21.pdf)
- 2025.11.25 Bloomberg TV, Нийт гүйлгээний 98 орчим хувь цахимаар хийгдэж байна,  
<https://www.youtube.com/watch?v=vi9Zfi8uOQ0>
- 2025.11.18 Монголын Үндэсний Телевиз, Google Pay үйлчилгээ нэвтрүүлсэн тухай,  
<https://www.facebook.com/mnbmongoliinmedee/videos/1144233164528711/>
- 2025.10.14 Стэйблкойн, токенжсон хуримтлалыг судалж, турших шаардлагатай,  
<https://www.inews.mn/a/46240>
- 2025.10.13 Үндэсний төлбөрийн системийн зөвлөлийн хурал зохион байгуулсан тухай  
<https://www.mongolbank.mn/mn/r/10643>
- 2025.01.10 Apple Pay үйлчилгээ нэвтэрсэн тухай,  
<https://ikon.mn/n/3blz>
- 2024.02.07 gogo.mn, Apple Pay үйлчилгээ нэвтрүүлэхээр ажиллаж байна,  
<https://www.facebook.com/qoqo.mn/videos/709178701201501/>
- 2024.06.09 Тэнгэр ТВ, Монголын эдийн засгийн чуулган 2024,  
<https://www.facebook.com/tnqr.tv/videos/832984728437474/>
- 2023.07.07 "Big Data" системийг нэвтрүүлснээр банкуудын тайлан тооцоог өдөр бүр хүлээн авах боломж бүрдэнэ,

	<ul style="list-style-type: none"> <li>- <a href="https://www.itoim.mn/a/2023/07/07/economy/loi">https://www.itoim.mn/a/2023/07/07/economy/loi</a> 2023.07.03 Шатахууны төлбөр тооцоог юаниар саадгүй хийж байна <a href="https://gogo.mn/r/7vvylo">https://gogo.mn/r/7vvylo</a></li> <li>- 2022.06.22 Төлбөрийн системийн хөгжлийн ирээдүйн чиг хандлага <a href="https://news.mn/r/2567469/">https://news.mn/r/2567469/</a></li> <li>- 2022.06.22 Үндэсний төлбөрийн системийн зөвлөлийн хурал зохион байгуулсан тухай <a href="https://www.mongolbank.mn/mn/r/1158">https://www.mongolbank.mn/mn/r/1158</a></li> <li>- 2022.03.28 Төлбөрийн системийн оролцогчдод сургалт зохион байгуулсан тухай <a href="https://www.mongolbank.mn/mn/r/732">https://www.mongolbank.mn/mn/r/732</a></li> <li>- 2022.03.09 Банкны нийт гүйлгээний 95 орчим хувь нь цахимаар хийгдэж байна <a href="https://ikon.mn/n/2hk4">https://ikon.mn/n/2hk4</a></li> <li>- 2021.11.25 Frontier Fintech Summit 2021 <a href="https://www.facebook.com/MongolianFintechAssociationNGO/videos/300142048644951">https://www.facebook.com/MongolianFintechAssociationNGO/videos/300142048644951</a></li> <li>- 2021.11.18 Цахим мөнгө нь санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэв <a href="https://ikon.mn/n/2dx9">https://ikon.mn/n/2dx9</a></li> <li>- 2021.11.18 Койныг төлбөрийн хэрэгсэл болгохгүй, <a href="https://www.facebook.com/zariqmn/videos/1125531578215041/">zarig.mn</a> <a href="https://www.facebook.com/zariqmn/videos/1125531578215041/">https://www.facebook.com/zariqmn/videos/1125531578215041/</a></li> <li>- 2021.08.25 Төлбөрийн системийн оролцогчдод зөвшөөрөл олгосон тухай <a href="https://www.mongolbank.mn/mn/r/598">https://www.mongolbank.mn/mn/r/598</a></li> <li>- 2021.03.18 Виртуал ханшийн өөрчлөлт, цахим халдлагын эрсдэлийг шинэ хуулиар зохицуулахгүй, <a href="https://gogo.mn/r/4wxdn">https://gogo.mn/r/4wxdn</a></li> <li>- 2021.02.23 Bloomberg TV, Цахим төлбөр тооцооны аюулгүй байдлыг хангах, <a href="https://www.youtube.com/watch?v=TvCplBZjYcE">https://www.youtube.com/watch?v=TvCplBZjYcE</a></li> </ul>
--	---

## ХОЁР. ХИЙХ АЖИЛ, НЭР ДЭВШСЭН ҮНДЭСЛЭЛЭЭ БИЧСЭН ТАЙЛБАР

2.1	<p>Тухайн албан тушаалд томилогдвол хийх ажил, уг албан тушаалд нэр дэвшсэн үндэслэлээ тайлбарлаж тодорхой, ойлгомжтой бичнэ /500-1000 үгэнд багтаана/.</p> <p><b>НЭГ. НЭР ДЭВШИХ ҮНДЭСЛЭЛ:</b></p> <p>Монголбанк нь үндэсний мөнгөн тэмдэгтийн тогтвортой байдлыг хангах үндсэн зорилтын хүрээнд санхүүгийн зах зээл, банкны тогтолцооны тогтвортой байдлыг хангах замаар эдийн засгийн тэнцвэртэй хөгжилд дэмжлэг үзүүлэх юм. Миний бие Төв банкинд 16 жил ажилласан туршлагадаа үндэслэн энэхүү хариуцлагатай албанд нэр дэвшиж байна. Миний ажлын туршлага мэргэжлийн, бодитой, оновчтой шийдвэр гаргах боломжийг олгоно гэдэгт итгэлтэй байна.</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Монголбанкны Валют, эдийн засгийн газар: (Гадаад валютын нөөцийн туршлага)</li> </ol> <p>Тус газрын мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх, санхүүгийн зах зээлийн үйл ажиллагаа эрхлэх, гадаад валютын улсын нөөцийг эзэмшиж удирдах, Засгийн газрын санхүүгийн зуучлагчийн үүргийг гүйцэтгэх, төв банкны санхүүгийн хэлцлийг гүйцэтгэх чиг үүргийн хүрээнд ГВУН-ийг хөрвөх чадвар, найдвартай байдал, эрсдэлээр жигнэсэн өгөөжийн зохистой тэнцвэрийг хангах олон улсын нийтлэг зарчимд нийцүүлэн удирдахад гар бие оролцож байсан туршлагатай.</p> <ol style="list-style-type: none"> <li>2. Монголбанкны Хяналт шалгалтын газар (Банкны хяналт шалгалтын туршлага):</li> </ol> <p>Тус газрын банкны салбарын тогтвортой байдлыг хангах, банкны харилцагч, хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор банкны үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүргийн хүрээнд банкны үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох, банкны өөрийн хөрөнгө, төлбөрийн чадварыг</p>
-----	--

хангуулах, удирдлага зохион байгуулалтын үндсэн зарчмыг тогтоох, үйл ажиллагааг нь зохицуулах, хязгаарлалт хийх, шаардлага тавих, албадлагын арга хэмжээ авах, зээлийн мэдээллийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хяналт тавихтай холбоотой үйл ажиллагаанд оролцож байсан ажлын туршлагатай.

3. Монголбанкны Төлбөр тооцоо, бүртгэлийн газар (Төлбөрийн систем, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн туршлага):

Монголбанкны нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн хэрэгжүүлж, санхүүгийн тайланг үнэн зөв, цаг хугацаанд нь бэлтгэх, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсронгуй болгох, Засгийн газар, банкуудын болон бусад харилцагчийн төлбөр тооцоог гүйцэтгэх ажлыг удирдан зохион байгуулж байсан туршлагатай.

4. Монголбанкны Төлбөр тооцооны газар (Төлбөр тооцооны систем, мэдээллийн технологийн туршлага):

Санхүүгийн тогтвортой байдлыг хангах, мөнгөний бодлогыг амжилттай хэрэгжүүлэх зорилтын хүрээнд Үндэсний төлбөрийн системийг олон улсын стандартад нийцүүлэн хөгжүүлэх, төлбөрийн системийн нийт оролцогчийн үйл ажиллагаанд хяналт тавих, дэвшилтэт технологид суурилсан төлбөрийн хэрэгслийг нэвтрүүлэх, төлбөрийн системийн тасралтгүй, найдвартай байдлыг хангахын зэрэгцээ Монголбанкны суурь бүртгэлийн систем, мэдээллийн систем, програм хангамж, мэдээллийн технологийн дэд бүтцийг хөгжүүлж, шинэчлэх, мэдээллийн болон кибер аюулгүй байдал, үйл ажиллагааны тасралтгүй, найдвартай байдлыг ханган, мэдээллийн технологийн шинэчлэлийг нийт ажилтнуудад хүртээмжтэй хүргэх ажлыг удирдан зохион байгуулж байна.

Монголбанкны мэргэжилтнээс эхлэн газрын захирлаар ажиллаж, Монголбанкны үндсэн гол газруудыг удирдан зохион байгуулж байсан туршлага маань надад давуу талыг олгоно.

## **ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ**

Монголбанк хуулиар хүлээсэн үндсэн үүргээ илүү хариуцлагатай, тууштай биелүүлэхийн тулд 1) инфляцыг Монголбанкны зорилтот түвшинд хадгалах, үнийн тогтвортой байдлыг хангах, 2) санхүүгийн тогтвортой байдлыг хангах, 3) төв банкны засаглалыг бэхжүүлж, цахим шилжилтийг эрчимжүүлэх гэсэн гурван зорилтыг дэвшүүлэн ажиллах бөгөөд энэхүү 3 зорилтын хүрээнд дор дурдсан арга хэмжээг хэрэгжүүлнэ.

### **АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ**

1. **Төв банкны бие даасан, хараат бус байдлын үнэлгээг сайжруулна.** Монголбанкны бие даасан, хараат бус байдлыг сайжруулж, ОУВС-гийн IАРОС индексийн аргачлалаар төв банкны хараат бус байдал, засаглалын одоогийн үнэлгээ 63 хувь байгааг сайжруулна.
2. **Орон сууцны ипотекийн хөтөлбөрийн үйл ажиллагаанд оролцох оролцоог бууруулна.** Ипотекийн зээлийн санхүүжилтийг нэгдсэн удирдлагаар хангах “Орон сууцны санхүүжилтийн банк” байгуулах асуудлыг судалж, холбогдох хуулийн төслийг боловсруулан, батлуулах зэрэг ажлыг Засгийн газартай хамтран зохион байгуулна.

Энэхүү бүтэц нь ипотекийн хөтөлбөрийг Засгийн газрын болон бусад эх үүсвэрээр дагнан санхүүжүүлэх чиг үүрэгтэй байна. Ингэснээр төв банк хөтөлбөрийн санхүүжүүлэгч байхаас бүрэн татгалзаж, зөвхөн хяналт шалгалтын чиг үүргийг хэрэгжүүлэх боломж бүрдэнэ. Түүнчлэн ипотекийн зээлээр баталгаажсан үнэт цаасны хоёрдогч зах зээлийг хөгжүүлнэ. Энэ хүрээнд хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийг хөгжүүлэх ажилтай үялдуулан Монголбанкны эзэмшилд байгаа ипотекийн зээлээр баталгаажсан бондыг хоёрдогч зах зээлд арилжаална. Ингэснээр хөтөлбөрийн санхүүжилтийг зөвхөн Төв банкнаас хамааралтай байх тогтолцоог халж, арилжааны банкнууд, даатгалын компаниуд болон хөрөнгө оруулалтын сангуудын чөлөөт эх үүсвэрийг ипотекийн зах зээл рүү татан оролцуулах нөхцөл бүрдэх юм.

3. **Засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналт (GRC)-ын тогтолцооны үр нөлөөг сайжруулна.** Дотоод аудитын үйл ажиллагааг олон улсын стандартад нийцүүлж, эрсдэлд суурилсан аргачлалыг нэвтрүүлж, аудитын төлөвлөлт болон гүйцэтгэлд эрсдэлийн үнэлгээ хийнэ. Улмаар тасралтгүй аудит болон мониторингийн аргачлалыг үе шаттай нэвтрүүлж, өгөгдөлд суурилсан хяналтын чадавхыг бэхжүүлнэ. Үр дүнд эрсдэлийн өөрчлөлт, хяналтын сул талыг илрүүлж, удирдлагын шийдвэр гаргалтыг шүүрхай, оновчтой мэдээллээр дэмжинэ.
4. **Их өгөгдлийн удирдлагын тогтолцоог бүрдүүлнэ.** Төв банкны хэмжээнд их өгөгдлийн засаглал, мэдээллийн удирдлагын тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлэх, өгөгдлийг нэгтгэх, хадгалах, түгээх үйл ажиллагааг зохицуулах стандартыг боловсруулан хэрэгжүүлнэ. Ингэхдээ мөнгө, санхүүгийн статистик, гадаад секторын статистик болон банкны салбарын тоон мэдээллийг цуглуулах, боловсруулах, түгээх үйл ажиллагааны өгөгдлийн урсгалыг үе шаттай автоматжуулж, бодлогын шийдвэр гаргалтын чанарыг дээшлүүлнэ.
5. **Мөнгөний бодлогын санхүүгийн зах зээлд шилжих сувгийн үр нөлөөг дунд хугацаанд дээшлүүлэх зорилгоор үнэт цаасны бүртгэлийн нэгдсэн системийг үе шаттайгаар нэвтрүүлнэ.** Энэ хүрээнд Монголбанк, ҮЦТХТ, МХБ-ийг хамарсан үнэт цаасны бүртгэл, төлбөр тооцооны нэгдсэн дэд бүтцийг бүрдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлнэ. Эдгээр ажлыг бодитоор хэрэгжүүлснээр санхүүгийн салбарын дэд бүтэц цогц хэлбэрээр хөгжиж, мөнгөний бодлогын санхүүгийн зах зээлд дамжих үр нөлөө нэмэгдэхийн зэрэгцээ хөрөнгийн зах зээлийн хөгжил эрчимжиж, зах зээлийн гүнзгийрэл, хөрвөх чадвар сайжрах нөхцөл бүрдэнэ.
6. **ЗГҮЦ-ны зах зээлийг хөгжүүлж, өгөөжийн муруйг бүрдүүлэхэд чиглэсэн бодлогын орчин, зах зээлийн дэд бүтцийг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ.** Дотоодын зах зээл дэх эрсдэлгүй үнэт цаас (ЗГҮЦ болон ТБҮЦ)-ны нийт үлдэгдлийн 98.3 хувийг ТБҮЦ бүрдүүлж байна. Олон улсын төв банкнуудын нийтлэг жишгээр нээлттэй захын үйл ажиллагааг ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээлээр дамжуулан хэрэгжүүлдэг. Иймд ТБҮЦ-ны хэмжээг алгуур бууруулах, төгрөгөөр илэрхийлэгдсэн ЗГҮЦ-ыг ялгаатай хугацаатайгаар тогтмол гаргах, зах зээлийн гүнзгийрлийг нэмэгдүүлэх чиглэлээр Сангийн яамтай хамтран ажиллана.
7. **Гадаад валютын дуудлага худалдаанд оролцох Төв банкны оролцоог үе шаттай бууруулах замаар гадаад валютын ханшийг зах зээлийн зарчимд шилжүүлнэ.** Монголбанк гадаад валютын зах зээл дэх өөрийн үүрэг оролцоог зах зээлийн зарчимд нийцүүлэн, идэвхтэй оролцогчийн байр сууринаас бодлогын зохицуулагчийн байр сууринд үе шаттайгаар шилжинэ. Сүүлийн жилүүдэд Төв банк богино хугацааны огцом хэлбэлзлийг намжаахаас илүү зах зээлийн байнгын оролцогч болоод байна. Иймд гадаад валютын дуудлага худалдааг үе шаттайгаар бууруулж, зогсоох, своп хэлцлийн үйл ажиллагаанаас үе шаттайгаар гарах, гадаад валютын үүсмэл хэрэгслийн зах зээлийн хөгжлийг дэмжих, оролцогчид ханшийн эрсдэлээ өөрсдөө удирдах боломжийг

нэмэгдүүлнэ. Энэхүү шинэчлэлийн үр дүнд банк хоорондын валютын захын өөрөө зохицуулагдах механизм бэхжиж, Монголбанк валютын нөөцөө оновчтой удирдах замаар төгрөгийн үнэ цэнийг бодитоор хамгаалах, санхүүгийн тогтвортой байдлыг хангах илүү таатай нөхцөл бүрдэх юм.

8. **Зах зээлийн зарчимд нийцүүлэхэд валютын захын өөрөө зохицуулах механизм хамгийн чухал тул гадаад валютын арилжааны дэд бүтцийг хөгжүүлнэ.** Дунд хугацаанд валютын ханшийг зах зээлийн зарчимд нийцүүлэхийн тулд валют арилжаа, гадаад гүйлгээний мэдээллийн нэгдсэн системийг бүрдүүлнэ. Өнөөдрийн байдлаар арилжааны банкнуудын валютын гүйлгээний мэдээллийг бодлогын шийдвэрт ашиглаж байгаа ч бэлэн валютын арилжаа эрхлэх зөвшөөрөл бүхий ББСБ-ын нэгдсэн тайлангийн систем дутагдалтай байна. Иймд зах зээлийн оролцогч бүрийн мэдээллийг багтаасан нэгдсэн санг байгуулж, системийн зураглал, хөгжүүлэлт, түршилтын ажлыг үе шаттайгаар гүйцэтгэнэ. Үүний зэрэгцээ гадаад валютын эрсдэлийг удирдах үүсмэл хэрэгслийн зах зээлийг идэвхжүүлж, банкны салбарын гадаад зах зээлээс татсан эх үүсвэрт эзлэх Монголбанкны урт хугацаат своп хэлцлийн хувь хэмжээг үе шаттай бүүруулна. Энэхүү дэд бүтцийн шинэчлэл нь гадаад валютын захыг илүү ил тод, өгөгдөлд суурилсан болгохоос гадна ханшийн эрсдэлийг удирдах зах зээлийн механизмыг бэхжүүлэхэд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэнэ.
9. **Гадаад валютын нөөцийг оновчтой удирдаж, хүрэлцээг нэмэгдүүлнэ.** Монголбанк гадаад сектор болон төлбөрийн тэнцлийн нөхцөл байдалтай уялдуулан гадаад валютын улсын нөөц (ГВУН)-ийг оновчтой удирдах, гадаад валютын цэвэр нөөцийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд ОУВС-гийн “ARA metric” аргачлалын дагуу нөөцийн хүрэлцээтэй байдал 2025 онд 73 хувь байгааг 100 хувьд хүргэж нэмэгдүүлэх чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд: Монголбанкны гадаад эх үүсвэрийг оновчтой удирдах замаар хүүгийн зардлыг бүүруулна, ГВУН-ийн хөрөнгө оруулалтын бодлого болон бүтцийг сайжруулж, хэрэгслийг төрөлжүүлнэ, Үнэт металл тушаалтыг хялбар болгох, хариуцлагатай уул уурхайг дэмжиж, төсөл хэрэгжүүлэх замаар үнэт металлын худалдан авалтыг дэмжих, Ирээдүйн өв сангийн хөрөнгийн удирдлагыг үрсгал тэнцэл, гадаад өр төлбөрийг харгалзан хуримтлуулдаг байх цаашлаад энэхүү эх үүсвэрийг ГВУН-д дарамт багатайгаар тусгаарлах нөхцөлийг бүрдүүлж, үе шаттайгаар хэрэгжүүлэх бэлтгэлийг хангана.
10. **Банкны хяналт шалгалтын тогтолцоог сайжруулж, олон улсын стандартад шилжинэ.** Монголбанкнаас банкнуудын үйл ажиллагаанд тавих хяналт шалгалтыг Базел стандартын өөрийн хөрөнгийн шаардлага болон хөрвөх чадварын шаардлагад нийцүүлэн, хараат бус, бие даасан байдлаар хэрэгжүүлж, банкны салбарын эрүүл, эрсдэл даах чадвартай банкны тогтолцоог нэвтрүүлнэ. Банкны тухай хууль тогтоомж болон хяналт шалгалтын холбогдох журам, зааврыг Базел стандартын “Банкны үр нөлөөтэй хяналт шалгалтын үндсэн зарчмууд”-тай нийцүүлэн шинэчлэн баталж, 2030 онд багтаан хөндлөнгийн байгууллагаар үнэлүүлэх (FSAP) ажлыг эхлүүлж, эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг бүрэн нэвтрүүлэх суурийг бүрдүүлнэ. Банкны эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоог нэвтрүүлснээр, банканд учирч болзошгүй эрсдэлтэй үйл ажиллагаа, төлбөрийн чадварт нөлөөлөхүйц эрсдэлийг эрт илрүүлж, урьдчилан сэргийлэх болон албадлагын арга хэмжээг оновчтой авах боломж бүрдэнэ. Улмаар банкнуудын эрсдэл даах чадвар нэмэгдэх, банкны системийн чанаргүй зээлийн түвшин бодитоор буурч, банкны салбарын дунд хугацааны тогтвортой байдал хангагдана. Монголбанкнаас эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг Базел стандартад нийцүүлэн хэрэгжүүлж эхэлснээр Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа банкнуудын гадаадын хөрөнгө оруулалт нэмэгдэх, олон улсад хувьцаагаа арилжаалах болон бүртгүүлэх (dual listing), банкны хувьцаа эзэмшигчдийн төвлөрөл буурах зэрэг эерэг нөлөө үзүүлнэ.

- 11. Банкны хувьцаа эзэмшигчдийн төвлөрлийг бүүруулж, засаглалыг сайжруулна.** Банкны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсгийн хэрэгжилтийг хангуулах, энэ хүрээнд холбогдох хуульд нээлттэй хувьцаат компани хэлбэртэй банкны нийт гаргасан хувьцааны 34, тухайн хаалттай хувьцаат компани хэлбэртэй банкны нийт гаргасан хувьцааны 51 хувиас тус тус хэтрэхгүй байх холбогдох зохицуулалтын саналыг боловсруулж, хууль өргөн баригчид хүргүүлж, өөрчлөлтийг мөрдүүлэх, Банкны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.15 дахь хэсэгт заасан шаардлагыг Монгол Улсын нэгдэн орсон олон талт, гишүүдийнхээ хөгжлийг дэмжих зорилго бүхий олон улсын санхүү/хөгжлийн байгууллага ("Multilateral development financial institution")-ын хувьд уян хатан байдлаар тусгах холбогдох зохицуулалтын саналыг боловсруулах, хууль өргөн баригчид хүргүүлж, өөрчлөлтийг мөрдүүлэх, Банкны хувьцаа эзэмшигчдийн төвлөрлийг бүүруулах шаардлагыг 2029 оноос хангах, Банкнуудын өмчийн хэрэгслийг бусад улс орны хөрөнгийн биржид бүртгүүлэх явдлыг дэмжих зорилгоор дотоодын хяналт шалгалтын зохицуулалт, бодлого нь Базел стандарттай нийцэж буй эсэхийг эрх бүхий этгээдээр үнэлүүлэх (FSAP-д хамрагдах), хууль тогтоомжид оруулах шаардлагатай өөрчлөлтийг тодорхойлж, төслийг боловсруулах.
- 12. Банкны салбарт гадаадын банк үйл ажиллагаа эрхлэх эрх зүйн орчныг сайжруулна.** Гадаадын банк Монгол Улсад үйл ажиллагаа явуулах хууль эрх зүйн орчныг сайжруулснаар гадаадын шууд хөрөнгө оруулалт өсөж, банкны салбарт өрсөлдөөн нэмэгдэж, хүний нөөцийн үр чадвар дээшилж, технологийн дэвшлийг богино хугацаанд эзэмшиж, дотоодын банкнуудын үзүүлэх боломжгүй санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөл олширч, санхүүгийн хүртээмж өргөжих боломжтой. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын зорилтын хүрээнд гадаадын банк, түүний салбарын эрх зүйн зохицуулалтын орчин сайжирч байгаатай холбогдуулан Монголбанк банканд хяналт тавих зохицуулалтыг нарийвчлан төрөлжүүлэх, санхүүгийн салбарт хөрөнгө оруулалтыг дэмжих шаардлагын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд: а) Банкны тухай хууль тогтоомжид гадаад улсын банк, санхүүгийн байгууллагын салбар, төлөөлөгчийн газрыг байгуулах талаар холбогдох зохицуулалтын саналыг боловсруулж, хууль өргөн баригчид хүргүүлэх, б) Гадаад улсын банкны харьяалагдах улсын зохицуулагч байгууллагатай хяналт шалгалт, албадлагын арга хэмжээ авах харилцан ойлголцлын санамж бичиг, хамтран ажиллах гэрээ байгуулах, в) Хамтарсан хяналт шалгалт, бүтцийн өөрчлөлт, татан буулгах арга хэмжээг зохицуулсан хууль эрхзүйн орчныг бүрдүүлэх.
- 13. Тогтвортой хөгжил, ногоон санхүүжилтийн бодлогыг дэмжинэ.** Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй банк, санхүүгийн салбар, зах зээлийг бүрдүүлэхийг зорино. Уг зорилтыг Монгол Улсын Үндэсний зорилт, уур амьсгалын өөрчлөлтийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигтэй уялдуулан хэрэгжүүлж, 2030 он гэхэд банкны салбарын ногоон зээлийн багцыг нийт зээлийн багцын 10 хувьд хүргэнэ. Энэ зорилтыг биелүүлэхэд хяналт шалгалт, уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэлийн тайлагнал, толилуулга зэрэгтэй холбоотой эрх зүйн орчин, зохицуулалтыг боловсронгуй болгох, үйл ажиллагааг тогтвортой хөгжлийн зорилтуудтай нийцүүлэх, санхүүгийн салбарын хүний нөөцийг чадавхыг бэхжүүлж, олон улсын болон дотоодын байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэн ажиллана.
- 14. Төлбөрийн системийн дэвшилтэт технологийг нутагшуулна.** Монголбанкны Инновацийн төвийн үйл ажиллагааг өргөжүүлж, төлбөрийн системийн оролцогчид харилцан санал солилцох, технологийн чиг хандлагыг хэлэлцэх, шинэлэг төсөл, санаачилгуудыг дэмжих нээлттэй платформ болгон хөгжүүлнэ. Улмаар олон улсын зах зээлд борлуулсан бараа бүтээгдэхүүний төлбөрийг хялбар хүлээн авах дэвшилтэт төлбөрийн хэрэгслийг Монгол Улсад нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлж ажиллана. Мөн финтек байгууллагууд болон төлбөрийн системийн нийт оролцогчдын дэд бүтцэд

суурилсан гүйлгээ дамжуулах туршилтуудыг үе шаттайгаар гүйцэтгэнэ. Олон улсын шинэ, шинэлэг төлбөрийн хэрэгсэл үйлчилгээг хараахан нэвтрүүлээгүй байгаа оролцогчдод дэмжлэг үзүүлэх замаар хамрах хүрээг тэлж, иргэд болон бизнес эрхлэгчид дэлхийн жишигт нийцсэн санхүүгийн үйлчилгээг саадгүй авах таатай орчныг бүрдүүлнэ. Ингэснээр үндэсний төлбөрийн систем олон улсын сүлжээнд бүрэн интеграцилагдаж, дижитал шилжилтийг шинэ шатанд гаргах юм.

15. **Дэвшилтэт технологи бүхий төлбөр тооцооны нөөц төвтэй болно.** Олон улсын төв банкнууд мэдээллийн нөөц төвийг хиймэл оюун ухаанд суурилсан хяналтын систем, эрчим хүчний хэмнэлттэй шийдэл, ногоон эрчим хүч ашиглах технологитой уялдуулан хөгжүүлж буй хандлагыг Монгол Улсад нутагшуулна. Энэхүү нөөц төв нь үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангаад зогсохгүй, урт хугацаанд ашиглалтын зардлыг бууруулах, байгаль орчинд ээлтэй, тогтвортой хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх ач холбогдолтой юм. Нөөц төвийг байгуулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх бөгөөд технологи, байршлын нарийвчилсан судалгаанд үндэслэн барилгын зураг төсөл болон угсралтын ажлыг гүйцэтгэнэ. Барилга угсралттай зэрэгцэн мэдээллийн технологийн дэд бүтэц, сервер, сүлжээний тоног төхөөрөмжийн суурилуулалтыг орчин үеийн стандартын дагуу хийж, онцгой байдлын үед үндсэн системээс шуурхай шилжин ажиллах боломж бүхий тохируулга, туршилт, нэвтрүүлэлтийг иж бүрэн гүйцэтгэнэ. Ингэснээр төлбөр тооцооны системийн тасралтгүй үйл ажиллагаа бэхжиж, санхүүгийн салбарын мэдээллийн аюулгүй байдал шинэ шатанд гарах юм.

#### **ГУРАВ. ДҮГНЭЛТ**

Миний санал болгож буй эдгээр хэрэгжүүлэх арга хэмжээ нь миний өнгөрсөн хугацаанд хуримтлуулсан туршлага дээр суурилсан бөгөөд амжилттай хэрэгжсэнээр инфляцын түвшин нам дор түвшинд тогтворжих, төв банкны өөрийн хөрөнгийн дутагдал арилах, гадаад валютын ханш зах зээлийн зарчмаар тогтох, гадаад валютын улсын нөөцийн удирдлага сайжрах, банкны хяналт шалгалт олон улсын стандартад нийцэх зэрэг бодит үр дүнгүүд гарч улмаар зээлийн хүү буурах, эдийн засгийн урт хугацааны тогтвортой өсөлт бий болох боломж бүрдэнэ.

#### **Хавсралт:**

*Холбогдох хуульд заасан шаардлагыг хангасныг нотлох дараах болон бусад баримт бичгийг нэр дэвших тухай хүсэлтэд хавсаргана:*

- төрийн албан хаагчийн анкет;
- эрх бүхий байгууллагаас нэр дэвшүүлсэн албан бичиг, шийдвэр;
- иргэний үнэмлэхийн хуулбар;
- нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар, эсхүл түүнтэй адилтгах баримт бичиг;
- боловсролын зэргийн дипломын хуулбар;
- хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг;
- Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 26.3 дахь хэсэгт заасан чиглэлээр мэргэшсэн, тухайн албан тушаалыг хашихад шаардлагатай түвшний мэдлэг, чадвар, туршлага, ёс зүйтэй гэдгийг нотлон харуулсан арваас доошгүй тодорхой үйл ажиллагааны талаарх баримт;
- энэхүү загварт заасан баримт бичиг;
- холбогдох бусад баримт.

#### **Хүсэлт гаргагч:**

Эцэг/эхийн нэр: Энхболд

Өөрийн нэр: Анар

Гарын үсэг:



Он, сар, өдөр:

2026.06.05